

## АГУУЛГА

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
1.1 Төслийн нэр.....	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	2
1.3 Төслийн хүчин чадал .....	2
1.4 Уурхайн дэд бүтэц .....	2
1.5 Уурхайн ажиллах горим.....	2
1.6 Усан хангамж .....	3
1.6 Цахилгаан хангамж.....	3
2.ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил,физик газар зүйн нөхцөл .....	4
2.2 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч .....	4
2.3 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг .....	5
2.4 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус.....	5
2.5 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засагын байдал .....	7
3.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙ.....	8
3.1 Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	8
3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	8
3.3 Гадаргын болон гүний усан үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	9
3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэжлэх хугцаа ,эрчим .....	9
4.2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
4.1 Агаар орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ .....	14
4.2 Хөрсөн орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ .....	17
4.3 Усан орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ .....	18
4.4 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ.....	18
4.5 Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
4.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	19
4.7 БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлцүүлэх хуваарь .....	20
4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	21
4.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал .....	

## 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр

Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших “Өмнөд-Алтан” хайлуур жоншны хүдэр Баяжуулах үйлдвэрийг ашиглах төсөл

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Хүснэгт 1

Төсөл хэрэгжүүлэгч	“ХЭРЛЭН-ИМПЕКС” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019073096
Регистрийн дугаар	2009765
Хаяг	Монгол, Дорноговь аймаг, Айраг сум 4-р баг, Цагаан дөрөлж, ТЗ өртөө
Утас	89118013

### 1.3 Төслийн хүчин чадал

**Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал:** Өмнөд-Алтан нэртэй баяжуулах үйлдвэрийг флотацийн аргаар 2024 онд 31.99 мян.тн хүдэр боловсруулан 97% агуулга бүхий 13.55 мян.тн эрдэсийн бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөгөөнд тусгаж байна.

### 1.4 Уурхайн дэд бүтэц

#### Уурхайн барилга байгууламж

Ажилчид таваараа амьдрах ажилчдын байр, конторын байр, хувцас угаалгын газар, бие засах болон ажилчдын халуун усны газар, дизелийн байр, агуулах, харуулын байр зэрэг барилга байгууламжууд байна. Агуулах, түлшний агуулах зэрэг байгууламжууд байна.

Хүснэгт 2 Байгууламжийн жагсаалт

№	Барилга байгууламж	Төрөл	Тоо
1	Дизелийн байр	сэндвич	1
2	Уурхайн хотхоны байр	контейнер	2
3	Цайны газар	контейнер	1
4	Халуун усны барилга	контейнер	1
5	Харуулын байр	сэндвич	1
6	Түлшний агуулах		1
7	Баяжуулах үйлдвэрийн байр		1
8	Захиргаа аж ахуйн байр		1
Хэсгийн дүн			9

### 1.5 Уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, хэрэглэгчдийн хэрэглээний хугацаанаас хамааруулан жилд 09 сараас 01 сар дуустал буюу 3 сарын хугацаанд нэг дор 50 хүн байрлах ба 7 цагийн үргэлжлэлтэй 3 ээлжээр ажиллуулахаар төлөвлөв.

### 1.6 Усан хангамж

Унд ахуйн болон технологийн хэрэгцээний усыг уурхайд байрлах 2 худгаас хангана. Худгуудын нийлбэр ундарга 4,5л/сек байна. Судалгааны талбайд хэрэглэгдэх усны хэрэгцээ нь:

- Унд, ахуйн хэрэгцээний ус
- Ногоон байгууламж усалгаа

- Замын усалгаа
- Үйлдвэрийн хэрэглээнд

Байгаль орчныг хамгаалах.цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм.

### 1.6 Цахилгаан хангамж

Төслийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг төвийн цахилгаан үүсгүүрээс авсан бөгөөд онцгой нөхцөлд DENYO маркийн дизель генераторуудаар шийдвэрлэнэ. Өмнөд-Алтатын хайлуур жоншны ордод ажиллах дизель генераторуудын техникийн үзүүлэлтийг дараах хүснэгтүүдэд үзүүлээ.

Хүснэгт 3 .Дизель генераторуудын үндсэн хэрэглэгчид

<i>№</i>	<i>Үзүүлэлт</i>	<i>Дизель генераторын марк</i>	<i>Ажиллах тоо, ш</i>
1	Ил уурхай угаан баяжуулах хэсэг	DENYO DCA 150USK	1
2	Ажилчдын хотхон, контор, засварын хэсэг	DENYO DCA 100ESI	1
3	Уурхайн гэрэлтүүлэг, Нөөцөд	DENYO DCA 150USK	1
<b>Нийт</b>		-	<b>3</b>

## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газар зүйн нөхцөл

Улаанбаатар хотоос 325 км, Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлана. Дорноговь аймгийн төвөөс 125 км, Айраг сумын төвөөс 10 км зайд байрлана.



Зураг № 1. Төслийн талбайн байрзүйн зураг

**Төслийн талбайн Физик газарзүй:** Өмнөд-Алтат хайлуур жоншны орд нь Монгол орны физик газарзүйн мужлалаар говь хээрийн бүсэд хамаарагдах ба цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай. Өмнөд-Алтат хайлуур жоншны орд нь ерөнхийдөө тэгш гадаргуутай далайн түвшингээс дээш 1200-1290 м-ийн өндөрт өргөгдсөн, төвийн ба зүүн өмнөд хэсгээрээ бага зэрэг доошоо сууж өгсөн байдалтай. Өндөр биш говийн уулархаг гадарга зонхилсон, районы 60 орчим хувь нь сулавтар налуу уналттай рельефээс тогтоно. Судалгааны талбайн төвийн болон хойд хэсгүүдээр далайн түвшингээс дээш 1100-1200 метрт өргөгдсөн жижиг гүвээлэг, толгодлог гадаргуу зонхилох бөгөөд уулуудын хооронд хөндий хөндийнүүд үргэлжлэх ба өргөн нь 6-10 км хүрнэ. Гадаргуу нь гол төлөв толигор, мөлгөрдүү байдалтай. Нутаг дэвсгэрийн өмнөд болон зүүн өмнөд хэсгүүдэд жижиг толгодлог алсаас налуу тал газрын байдалд аажмаар шилжсэн гадаргуугийн үнэмлэхүй өндөр нь далайн төвшнөөс дээш 1000-1100 м хүртэл намсан гадаргуу зонхилно.

**Хүн ам, дэд бүтэц: Замын сүлжээ -** Дорноговь аймаг нь манай орны урд хэсэгт Галба-Өөш-Долоодын говийн сав газарт оршдог. Тус аймаг нь 109.5 мянган км.кв нутаг дэвсгэртэй 14 сум, 60 багтай. Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар гэх 5 аймагтай хөрш оршдог. Урд талаараа БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг. Дорноговь аймгийн төв Сайншанд сум нь 234.2 мянган га нутаг дэвсгэртэй.

Дорноговь аймаг нь 69.6 мянган хүн амтай 21.7 мянган айл өрхтэй. Хүн амын 50.5 хувь нь эрэгтэй, 49.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 38.6 мянган хүн байна.

**Дэд бүтэц:** Тус аймагт 4 чиглэлийн 531 км урт төмөр зам, 722 км урт хатуу хучилттай авто зам, олон улсын агаарын тээвэр дайран өнгөрөх гурван нисэх буудалтай. Мөн Багануур - Сайншандыг холбосон 220 кВ, Сайншанд - Замын-Үүдийг холбосон 110 кВ, Сайншанд - Зүүнбаянг холбосон 35 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамтай.

АШУҮИС-ийн салбар сургууль, МСҮТ, Төмөр замын МСҮТ, ЕБ-ын 20 сургууль, 21 цэцэрлэг, эрүүл мэндийн 72 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Аж ахуй нэгжийн хувьд 6.2 хувь нь төрийн байгууллага, 93.8 хувь нь хувийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүд болон Ханги- Мандалын боомтуудтай.

**Эдийн засгийн байдал:** Дорноговь аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй, газар тариалан бөгөөд сүүлийн жилүүдэд аялал жуулчлал, уул уурхай, хүнс болон барилгын материалын үйлдвэрлэл хөгжиж байна. Оны эхний байдлаар аж үйлдвэрийн салбарт 71,966.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 126,852.3 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 9.5 хувиар, борлуулалт 75.8 хувиар тус тус өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5.6 хувийг төрийн, 94.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ. Аймгийн хэмжээнд бүх суманд төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон ба аймгийн нутаг дэвсгэрт цахилгаан холбооны үүрэн телефонтой.

**Айраг сүм:** нь 7.4 мян.хавтгай дөрвөлжин км талбай бүхий газар нутагтай. Далайн түвшнээс дээш 1250 м өргөгдсөн, даваа толгод, уул овоо, тал хөндий хосолсон газар нутагтай. Тус сум нийт 3.6 мянган хүн амтай үүний 51% эрэгтэйчүүд, 49% эмэгтэйчүүд байна.

Дорноговь аймгийн Айраг сум нь Улаанбаатар хотоос 330 км, аймгийн төв Сайншанд сумаас 130 км зайд оршдог. Сумын хэмжээнд нийт 39 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс уул уурхайн чиглэлээр 16, цахилгаан дулаан, эрчим хүчний чиглэлээр 1, ХАА-н чиглэлээр 2, газрын тосны чиглэлээр 2, эм эргэлтийн сан 1, шуудан тасаг 1, төсвийн байгууллага 6, олон нийтийн байгууллага 2, худалдаа үйлчилгээний 13, салбар 2, хоршоо 3 зэрэг байгууллага, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

**Цахилгаан хангамж:** Төвлөрсөн цахилгаан хангамжийн шугамаас 700 м зайтай. Ордыг ашиглах үйл ажиллагаанд төвлөрсөн цахилгаан хангамж, аваарийн дизель станцыг ашиглах боломжтой. Төсөлд өөрсдийн хөрөнгөөр Айрагийн төвийн эрчим хүчний ЦДАШ агаарын магистраль шугамаас 2000 кВА-ийн трансформатор бүхий дэд станцыг байгуулсан байна.

**Усны хангамж:** Талбайн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ муу хөгжсөн ба байнгын урсгал ус байхгүй. Ордын орчимд гол, булаг шанд байхгүй. Хур бороо элбэгтэй үед хуурай сайруудад түр зуурын урсгал ус бий болдог. Уурхайд ажиллагсдын ундны болон үйлдвэрлэлийн

хэрэглээний усыг гүний худгаас авч ашигладаг. Компани өөрийн хөрөнгөөр усны хайгуул хийж 6 цооног өрөмдсөн бөгөөд эдгээр цооногоос 2-3 цооног нь уурхайн болон үйлдвэрийн усны хэрэгцээг бүрэн хангана гэж тооцож байгаа. Талбайн урд ашиглаад орхисон “Хайрт” ын уурхай нь гүний усны ихээхэн нөөцтэй байгаа нь тус район гүний усны нөөц их байгааг батлан харуулж байгаа нэг жишээ юм.

**Цаг уур:** Уур амьсгалын хувьд дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Бүх нутгаар агаарын хэм харьцангуй жигд байдаг. Ургамалшил тачирхан, чулуурхаг буюу элсэрхэг гадаргатай тул наранд халж агаарын хэмийг нэлээд дээшлүүлдэг. Хамгийн их хүйтрэлт 1-р сард, хамгийн их халуун 7-р сард болдог. Өвөл 20-15° хааяа 36-40° хүрч хүйтэрнэ.

Дулааны улиралд 20-25° халах боловч 30° ба түүнээс дээш хэм халах явдал жилд дунджаар 30-39 хоног тохиолдоно. Чийгшилт дунджаар 45-50% байдаг. Ус чийг багатай тул манан бараг ажиглагдахгүй. Хур тунадасны хэмжээ маш ядмаг юм. Энэ нь хойд мөсөн далайн болон номхон далайн агаар нэвтрэн ирэх боломж муу байдаг, гол төлөв эх газрын эрс тэс уур амьсгалтай байдалтай холбоотой юм. Хур тунадас жилд 30 орчим хоног бороо орж 100 мм орчим тунадас унах, Цас маш бага орж цасан бүрхүүл бараг тогтдоггүй, 1-2 см хамгийн их нь 14 см хүрдэг бөгөөд 120-130 хоног цоохор цас тогтдогийг тогтоожээ. Хоногийн хэмийн

хэлбэлзэл их, салхийг хаах өндөр уул нуруу байхгүй тул салхины хоногийн хэлбэлзэл ихтэй байдаг.

Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 120 хоног байдаг. Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд 5.9 м/сек, хамгийн бага салхилалт өвөл буюу 4.2-4.3 м/сек- ийн дундаж хурдтай байдаг.

Жилийн салхины дундаж хурд 4.0 м/сек бөгөөд жилд дунджаар 32-38 хоног 15 м/сек хүртэл хүчтэй цасан ба шороон шуурга шуурна. Хүчтэй салхилах хугацаа 4-6 хүртэл хоног үргэлжлэх үе байдаг. Хамгийн тохиромж муутай улирал нь хавар юм. Намар удаан үргэлжилнэ. Өвөл салхи багатай дулаахан болдог. Харин зун ялангуяа 7-р сард их халдаг онцлогтой.

**Ан амьтан:** Амьтны аймгийн хувьд ургамлын бүрхэвч сийрэг боловч амьтны аймгийн тархалт тоо хэмжээний хувьд нэлээд их юм. Туурайтнаас хамгийн их тархсан нь цагаан зээр юм. Түүнчлэн жигүүртнээс тас, бүргэд, сар, элээ, хэрээ, харцага, ногтруу, өвөөлж, тоодог, хэвлээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгчдээс сохор номин, шар сүүлт, бозлог, алаг даага, тарвага, махчин амьтдаас үнэг, хярс, өмхий хүрэн, бага хэмжээгээр чоно, шавьж идэштнээс зараа зэрэг амьтад тохиолдоно.

Түүнээс гадна нүүдлийн шувууд хавар намарт цөөнгүй байдаг. Байгалийн тэнцвэрт байдлыг хангах, ховордсон амьтан ургамлыг хамгаалах зорилгоор говийн ихэнх амьтдыг агнах, заг зэрэг ургамлыг устгахыг хориглосон байдаг.

### **2.3 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг**

**Хөрс:** Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй хүрэн цайвар хүрэн, бор хүрэн, тал нам дор газартаа цайвар шаргал, хужирлаг өндөрлөг газартаа уулын хүрэн хүрвэтэр өнгийн хөрсүүд ялгагдана. Хүрэн цайвар болон бор хүрэн цайвар шаргал хөрс нь аллювиваль-нуурын гаралтай шавар, шавранцраас тогтоно. Хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2 м хааяа 30-40 см хүртэл хэлбэлзэнэ.

**Ургамал зүй:** Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл, хажуу, нам толгодод нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвч бүрэлдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялгана хазаар, агь, таана, хөмүүл, зангуу, божмог шарилж зэрэг болно. Дов толгодын гуу жалга, уулсын хажуу, нам газраар алтан харгана, хар харгана, дэрс буйлс, говирхог хэсэгтээ нохойн шийр бударгана ургадаг. Нутаг дэвсгэрийн хэмжээнд модлог ургамал байхгүй. Нуур булгийн эрэг орчмоор ургамлын бүрхэвч нь нэлээн шигүү ургана. Өвс ургамлын хувьд уг дүүрэг нь элсэн цөлийн болон говь хээрийн ургамал зонхилно. Ихэнхдээ дэрс бух нохойн хошуу, заг гэх мэт ургамал нэлээдгүй ургана.

### **2.4 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус**

Судлагдсан нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтмол урсгал ус байхгүй. Булгийн усаар тэжээгддэг жижгэвтэр горхинууд байна. Ойр орчимд 5-6 км-ийн зайтай цөөн тооны гүний худгуудтай. Нуур байсан хонхор тогооны гүн нь 1-3 м, талбайн хэмжээ нь 0.1-0.5 км<sup>2</sup> орчим бөгөөд зуны улиралд хур бороо ихтэй үед нуурын тогоо нь усаар дүүрэх боловч аажимдаа хатаж ширгэдэг. Талбайн хэмжээнд цөөн хэдэн худаг бий боловч үйлдвэрлэлийн нөхцөлд тэдгээр худгуудаас 3600-3900 л/цаг ус гаргах боломжтой.

Төслийн талбайн орчим гадаргуугийн ус ховор бөгөөд уурхайн худгаас дээж авч шинжлүүлэхэд үндсэн үзүүлэлтүүдээс ерөнхий хатуулаг болон магнийн ионы агууламж нь “Ундны усны чанарын стандарт MNS900:2018”- д заасан хэмжээнээс их байгаа тул хүний унданд тохиромжгүй, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай гэж үзжээ.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН

#### 3.1 Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

##### *Агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд*

“Өмнөд-Алгат” хайлуур жоншны орд, Баяжуулах үйлдвэрийг ашиглах явцад агаарын чанарт нөлөөлөх үүсгэх эх үүсвэрүүд нь:

- Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ.
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо
- Уурхайн машин техникүүдийн түлшний шаталтаас ялгарах утаа, тортог, хорт хийнүүд
- Ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол
- Өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй.

#### 3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Өмнөд-Алгат” хайлуур жоншны ордыг хосолмол аргаар ашиглах төслийн 3 сарын хугацаанд нийт 1,26 га талбай өөрчлөлтөнд орж хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөхөөр байна. Төслийн хүрээнд төлөвлөж буй уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн үйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг. Асгаралтын хэмжээ, түүний нөхцөл байдлыг зөв үнэлсэн тохиолдолд түүнийн нөлөө бага байдаг, ялангуяа, шаардлага хангасан шатахууны агуулах, асгаралтын хариу арга хэмжээ сайн байхаас хамаарна. Эдгээр арга хэмжээг Аюултай, хортой материалын менежментийн төлөвлөгөөнд тодорхой тусгасан байх ёстой.



Зураг № 7. Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвч

### 3.3 Гадаргын болон гүний усан үзүүлэх сөрөг нөлөөлөл

#### Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт нөлөөлөл бий болж болзошгүй. Үүнд:

- Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох
- Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох
- Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах
- Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах
- Техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уурхайн байгууламж, хоосон овоолго, хаягдлын сан, техник хэрэгслийн байршуулалт зэргээр газрын гадаргыг өөрчилж улмаар байгалийн хур тунадас унаж урсац бүрдэх, хөрсний чийг, газрын доорх усыг сэлбэх нөхцөлийг доройтуулах магад.

### 3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэлжлэх хугацаа ,эрчим

**Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим:** Уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, судалгаа хийсэн мэргэжлийн судлаачдын дүгнэлтүүдийг үндэслэн тогтоов. Байгаль орчны төлөв байдалд гарч болзошгүй нөлөөлөл, болзошгүй ослын үнэлгээг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

**Магадлан жагсаах /checklist/ аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ:** Үнэлгээ хийгдэж буй төслийн үйл ажиллагаа байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг тодруулахын тулд магадлан жагсаах (checklist) аргыг ашиглав. Энэ арга нь нөлөөллийг байна (х), байхгүй (хоосон) гэсэн хэлбэрээр тодорхойлж шууд, шууд бус шинжтэй, удаан, богино хугацаагаар буцалтгүй болон буцаж нөлөөлөх, хүчтэй, дунд болон бага зэрэг эрчимтэй байх зэрэг үзүүлэлтүүдээр авч үзсэн болно.

Төслийн байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эх үүсвэрүүдэд дараах хүчин зүйлс орж байна. Үүнд:

- 🚧 Хөрс хуулалт
- 🚧 Уурхайн олборлох, ачих, буулгах, тээвэрлэх үйл явц.

Төсөл хэрэгжсэнээр тухайн нутгийн байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг хүснэгт 4-д харуулав.




Хүснэгт 4. Магадлан жагсаах арга

Нөлөөлөл Хугацаа Давтамж Эрчим

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицувлдаг	Богино хугацаан	Удаан хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
<b>Байгалийн экосистемийн өөрчлөлт</b>											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт										
2	Гадаргын усны чанарын өөрчлөлт		x			x	x	x		x	
3	Ургамлан бүлгэмдлийн бүтцийн өөрчлөлт	x				x		x			x
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x			x
5	Геологийн тогтоцын өөрчлөлт					x		x		x	
6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x	
7	Уур амьсгалын өөрчлөлт	x	x			x		x	x		
<b>Байгалийн нөөцийн ашиглалт</b>											
8	Газрын доорх нөөц баялаг	x								x	
9	Бэлчээрийн байдал	x								x	
10	Эрдэс түүхий эдийн нөөц	x								x	
<b>Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
11	Агаарын бохирдол	x			x					x	
12	Ундны усны нөөц хомсдох		x						x		
13	Хөрсний бохирдол		x							x	
14	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x					x	
<b>Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>											
15	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x							x		
16	Хүн амын орлого өөрчлөгдөн нэмэгдэх		x						x		
17	Хүн амын тоо өөрчлөгдөх		x								
<b>Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор</b>											
18	Байгалийн өнгө төрх өөрчлөгдөх	x									x
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x								x	
20	Тусгай хамгаалалттай ба цогцолбор газарт нөлөөлөх										
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
22	Археологи, Палентологийн олдворт нөлөөлөх										
<b>Эдийн засаг, байгаль орчин</b>											
23	Орон нутгийн орлого нэмэгдэх		x			x		x		x	
24	Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x			x	x		
<b>Бусад нөлөөлөл</b>											
26	Уурхайн шороон зам, машин механизмын хөдөлгөөн тээвэрлэлтээс хөрс эвдрэх	x			x	x					x
27	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба ус бохирдуулах	x			x	x				x	
28	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x		x		x				x	
29	Хүчтэй салхи, уруйн үер	x		x		x				x	
	Дүн	18	8		5	20	7	18	5	15	6

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.



Тус ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэх ба 7.1% нь “бага”, 45.2% нь “дунд”, 42.8% нь “их”, 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Нөлөөлөлд өртөж буй байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдээс газрын гадарга, хэвлий нь нөлөөлөлд илүүтэйгээр өртөхөөр байна.

#### 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт “Хэрлэн-Импекс” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Өмнөд-Алтат” хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн ашиглах төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2024 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **сая.төг** зарцуулахаар төсөвлөв.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ӨМНӨД-АЛТАТ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД, ХҮДЭР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Агаар орчинд үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа					Давтамж Хугацаа	Хянах үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө мян.төг	
				2023	2024	2025	2026	2027			Нэгж зардал	Нийт
1	Хүдэр жигдрүүлэх талбай	Хүдэр жигдрүүлэлт дээр ажиллаж буй ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Хүдэр жигдрүүлэх талбай						1 жилд 4 удаа	MNS 5621: 2006	4,000.0	<b>4,000.0</b>
2		Уушги, зүрх судасны чиглэлээр эмчийн үзлэгт тогтмол хамруулж байх.							1 жилд 1 удаа	Агаарын тухай хууль	5,000.0	<b>5,000.0</b>
3		Жигдрүүлэх талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийн кабины дотор талын битүүмжлэлийг сайжруулах, агаарын тоосжилт хэмжигч багаж суурилуулж, дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянаж байх							Тогтмол	Агаарын тухай хууль	3000.0	<b>3,000.0</b>
4		Салхины хурд ихтэй үед ажиллахгүй арга хэмжээг дотоод журамдаа тусгаж өгөх							1 удаа	Агаарын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль	-	-
5	Гадаад болон дотоод тээвэрлэлтийн шороон зам	Шороон замыг хайрган хүчилттай болгох	Гадаад болон дотоод тээвэрлэлтийн шороон зам						1 удаа, гэхдээ тогтмол засаж сайжруулж байх	Агаарын тухай хууль		
6		Шороон зам дагуу тэмдэг, тэмдэглэгээ хийх								Агаарын тухай хууль, Хөрс хамгаалал, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	400.0	<b>400.0</b>
7	Уурын зуух	Уурын зууханд шүүлтүүр суурилуулах	Уурын зуух						1 удаа		8,900.0	<b>8,900.0</b>
8	Баяжуулах үйлдвэр болон уурын зуух	Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн дүгнэлтийг орон нутаг дахь агаарын чанарын мэргэжлийн албаар гаргуулах	Хууль эрхзүйн шаардлага								-	-
9		Агаарын чанарын мэдээ тайланг мөн агаарын чанарын мэргэжлийн албанд хуульд заасан хугацаанд гаргаж өгч байх.									-	-
10	Болзошгүй аюул, ослын үед хорт хий ялгарч, агаарын чанарт нөлөөлөх	Химийн бодис холих, уусгах үйлдлийг битүү саванд буюу хий тархахаас хамгаалсан нөхцөлд хийх	Лаборатори, агуулах, үйлдвэр						Тогтмол		-	-
11	Болзошгүй аюул, ослын үед хорт хий ялгарч, агаарын чанарт нөлөөлөх	Химийн бодисын хаягдал үлдэгдлийг үйлдвэрлэлийн хаягдал материал устгахад мэргэшсэн мэргэжлийн байгууллагаар устгуулах	Төслийн нийт талбайн хэмжээнд						Тогтмол		-	-

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ӨМНӨД-АЛТАТ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД, ХҮДЭР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

12		Химийн бодисын хаягдал үлдэгдлийг орон нутгийн мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл дүгнэлтийн дагуу устгах							Тогтмол		-	-
13		Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдэд учирсан гэмтлийг цаг тухай бүр янзалж, дотоод шаталтын хөдөлгүүрийг засварлаж, шинэчлэх							Тогтмол	Агаар орчныг бохирдуулах, хорт утаа ялгаралтыг бууруулна.	-	-
14	Ууршигтай, дэгдэмхий бодисууд уурших, исэлдэн-ангигрэх урвалд орох, салхины нөлөөгөөр тархах зэргээр агаарын чанарыг өөрчлөх	Химийн бодисын агуулах болон үйлдвэрийн үндсэн барилга байгууламжийн инженерийн төлөвлөлтийг хийхдээ газар хөдлөл, хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, үерийн аюулыг тооцож төлөвлөх	Төслийн нийт талбайн хэмжээнд						Тогтмол	Үйлдвэрийн барилга байгууламж барихдаа болзошгүй эрсдэлийг тооцож төлөвлөнө.	-	-
15		Химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шүүд тусахааргүй нөхцөлд хадгалах.	Төслийн нийт талбайн хэмжээнд						Тогтмол		-	-
16	Агаарын чанарт тогтмол хянаж ажиллах	Агаарын чанар, дуу шуугианы хяналт шинжилгээг тогтмол хийх, ОХШ-ний тэмдэглэл хөтөлж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн, анхаарах аюултай тохиолдол бүрийг судалж шаардлагатай хариу арга хэмжээг авч ажиллана.	Төслийн нийт талбайн хэмжээнд						Улирал тутамд	Зардлыг ОХШХ-т тусгав.	-	-
17		Үйлдвэрийн гол хэсгүүд, ажлын байр болон тогтоосон цэгт байнга тоосжилтын түвшний хэмжилт хийж байх ба хэрэв зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэргэвэл тэр даруй хяналтын арга хэмжээ авах	Төслийн нийт талбайн хэмжээнд						Тогтмол	Зардлыг ОХШХ-т тусгав.	-	-
<b>Нийт, мян.төг</b>												<b>21,300.0</b>

**4.2. Хөрсөн орчныг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ**

№	Газрын гадарга, Хөрсөн орчинд үзүүлэх гол ба болзошгүй нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа					Давтамж	Хянах үзүүлэлт, баримтлах стандарт, шаардлага, тайлбар	Шаардагдах хөрөнгө мян.төг	
				2023	2024	2025	2026	2027			Нэгж зардал	Нийт
1	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой үүсэх сөрөг нөлөөлөл	Тээврийн хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх засвар үйлчилгээ хийх талбайг тусгайлан засаж тохижуулах	Үйлдвэрийн талбайд						Тогтмол	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийх талбайг тусгайлан засаж тохижуулсан байна	400.0	<b>400.0</b>
2	Хаягдлын сангийн сөрөг нөлөөллийг бууруулах	Ногоон зурвас байгуулах	Хаягдлын сан						Тогтмол		5,587.3	<b>5,587.3</b>
3		Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах, хаягдлын сан орчмын	орчим 3 га талбайд ногоон						Эхний жил мэргэжлийн	MNS 5850:2019	8,000.0	<b>8,000.0</b>

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ӨМНӨД-АЛТАТ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД, ХҮДЭР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		бохирдсон хөрсийг хуулах, саармагжуулах	зурвас байгуулах, хаягдлын сангаас 200 м орчим газрын хөрсийг хуулж, саармагжуулах						байгууллагатай гэрээ байгуулж, хоёр дахь жил саармагжуулах арга хэмжээ авах			
